

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ҮЗЭЛ БОДОЛТОЙ  
БАЙХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б. Болд-Эрдэнэ\*

\* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор

*МУИС-ийн суурь судалгааны санхүүжилтээр бичив*

**Түлхүүр үг:** ардчилал, хүний эрх, чөлөөт хэвлэл, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, олон нийтийн санал асуулга

**А**рдчилал, хүний эрх, чөлөөт хэвлэлийн үндсэн зарчим нь хүн бүхэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй хэмээх томъёоллод нэгтгэгдэн өнөөг хүрсэн. Гэхдээ асуудлыг зөвхөн “толгойдоо орсон бүхнээ хүссэн үедээ цуурах” гэж хэтийтгэн ойлговол нэг талаас хүний мөн чанарын илэрхийлэл болсон оюун санаа сэтгэлгээний үнэлэмжийг үгүй хийх, нөгөө талаас нийгэм, соёл иргэншлийн хөгжил өөрчлөлтийн зорилгыг үл ухаарсан хэрэг болох нь дамжиггүй.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүний салшгүй, төрөлх эрх дарх мөн. Хэнд ч бусдын бодох, ярих, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг үгүйсгэх эрх мэдэл үгүй. Харин төр засаг, эрх баригчдын мөнхийн хүсэл зориг нь хүний оюун санааны эрх чөлөөг ямар нэг байдлаар хязгаарлахад оршиж байгаа нь төрийн нууц, улс орны эрх ашиг, засгийн газрын бодлого үйл хэргийн “сурталчилгааны түрэлт” зэр-

гээр бодит амьдралд бугшсаар буй нь нууц биш ээ.

Социализм, коммунизмын үзэл суртлын эрин үед төгсгөл тавиад 25 жил болсон өнөөгийн Монголын нийгэмд ч “үзэл бодол тойрсон” хяналт, төөрөгдүүлэлт хэвээр үргэлжилж байна. Мэдээж энэхүү үргэлжлэл нь шууд цагдан хяналт хорио хязгаарлалт бус, харин үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үнэ цэн, үнэлэмжийг үгүйсгэх, саармагжуулахад чиглэж багагүй “амжилт” олжээ. Нийгмийн халамж, сонгуулийн амлалт, популизмыг зорилгоо болгосон улс төрийн сэтгүүл зүй нь нийгэм, хүний сайн сайхны тухай хүн төрөлхтний бүх цагийн үзэл санааг увайгүй төөрөгдүүлэлтийнхээ “гишгүүр” төдий хэрэгсэл мэтээр ашигласаар ирсэн нь бидний эмгэнэл мөн.

Үзэл бодол нь өөрийн гэсэн үнэ цэнтэй, үнэнийг нээх мөн чанарт нийцэж байж сая жинхэнэ бодит, утга ач холбогдлоо хадгална. Тиймээс ч тэнцвэртэй, зөв, шудрага байр суурь, үндэслэлд тулгуурлан эрүүл саруул оюун дүгнэлтээр аливаад хандах нь үзэл бодлын шалгуур, эрэмбэ үнэлэмжийн үндсэн зарчим байдаг. Өөрөөр

хэлбэл үзэл бодол бүрэн тэнцүү, адил байх боломжгүй бөгөөд бүх талын харилцан зөвшилцөл, хүлцэн тэвчих хийгээд бодит байдал, үнэнд “гүйцэгдэх” уг чанараар тодорхойлогдоно гэсэн үг. Энэхүү зарчим, шалтгаанаар ч сэтгүүл зүйн мэдээллийн үнэ цэн, үнэн бодит байдлыг шүүдэг ба мэргэжлийн түвшин стандарт, ёс зүй, эх сурвалжийн чанарын ач холбогдлыг тодотгодог. Ийм шалгуур үнэлэлтээр телевизийн мэтгэлцээн, ярилцлагаас мэдээний агуулга эрэмбийг ч тогтоож, дүн шинжилгээ хийдэг.

Сэтгүүл зүй мэргэжлийн байх, эрх нөлөөтэй бие даасан нийгмийн тогтолцооны түвшинд үнэлэгдэх гэдэг ч үзэл бодлын мөн чанартай холбоотойн дээр нэг талаас мэдээллийн эрэлт хэрэгцээг хангаж ашиг орлоготой байх, нөгөө талаас хүний оюун санаа, итгэл үнэмшлийн нэгэн бодит ахуй, хүрээ болохуйн уг сурвалж билээ.

Гэхдээ “сэтгүүл зүйн үзэл бодол” хэмээх ойлголт энэ ертөнцөд үгүй. Тэгэхлээр хүний үзэл бодол түүний мөн чанарын тухай ярих болно. Хүний үзэл бодлыг ч үнэн ба худал, зөв болоод буруу гэж ангилна. Мэдээж ийнхүү ангилан үзсэний цаана шалгагдан нотлогдсон, сэтгэгдэл төсөөлөлд эрхшээгдсэн, оюун дүгнэлтээр шүүгдсэн, мэргэжлийн, шинжлэх ухаанч эсэх гээд олон ойлголт шалгуурыг онцолж буй хэрэг. Нөгөө талаар хүний үзэл бодолтой байх эрх чөлөөний үнэ цэн нь эрүүл, зөв, бодит байр суурь, хандлага бөгөөд тийм нийгмийн зөвшилцөл, нэгдмэл соёлын шалгуур дээдлэлийг бий болгох нь үзэл бодлын эрх чөлөөтэй байхуйн утга учир шалтгаан юм. Хэрвээ ийм түвшин, нөлөөнд хүрэхгүй аваас энэхүү эрхэм дээд эрх чөлөөний хэрэг, ач тус гэж үгүй болно. Нэг нь ярьж л байдаг, нөгөө нь үл

ойшоодог үзэл бодлын үнэ цэн гэж үгүйн дээр хэт даамжран угшваас хүний ч тэр, нийгмийн ч тэр мөн чанар, дэг журамд сөргөөр нөлөөлнө. Харамсалтай нь ийм нөхцөл, цаг үед бидний амьдрал, харилцаа өрнөж буй нь бодит үнэн. Бидний 2015 оны 5-р сард явуулсан 3700 хүний судалгаанд оролцогсдын 75 хувь нь (2709 хүн) үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж байгаа ч үр дүн үгүй, хоосон яриа мэтгэлцээн болж байна гэсэн нь асуудал тулгамдсан түвшинд хүрсний нотолгоо мөн. Түүнчлэн 19.3 хувь нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хязгаарлагдмал байгааг онцолсон нь дээрх тоо, дүр зургийг улам ч ноцтой болгож байна.

Гэтэл судалгаанд оролцогсдын 72.2 хувь (2621 хүн) үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зорилгыг “нийгмийн эерэг зөв шийдэл, асуудлын гарцыг олох” хэмээн үзсэн байгаа юм. Дээрх хоёр тоо баримтыг харьцуулан үзвэл үзэл бодлын эрх чөлөөний нийгмийн зүгээс хүлээж буй ашиг үр өгөөж ба бодит байдал хоорондын эрс зөрчил, ялгааг харж болно. Нөгөө талаар үзэл бодлын эрх чөлөөний үр өгөөжтэй, эерэг таатай орчныг бий болгох сэтгүүл зүй, мэдээллийн хэрэгслийн тогтолцооны нийгмийн өмнө хүлээсэн үүргийн хангалтгүй байдлыг нотолж байна. Тиймээс ч үзэл бодлын эрх чөлөөний “гол дайсан”-аар манай судалгаанд оролцогсдын 41.1 хувь (1377 хүн) нь далд хяналт, хязгаарлалт хэмээн үзсэн нь мэдээллийн төөрөгдүүлэлт, хэтийдэл, явцуу эрх ашиг, сонирхолд үйлчлэх болсон зэрэг шалтгаанаар тайлбарлаж байна.

Мөн 983 хүн буюу судалгаанд оролцогсдын 29.2 хувь нь “бодит үнэн мэдээлэл хомс тодорхой үзэл бодлыг дэмжихэд түвэгтэй” байдал нь

өнөөгийн тулгамдсан асуудал мөн хэмээн үзсэн нь учиртай. Өөрөөр хэлбэл, нийгмийн харилцааны утгаараа хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хүний зөв, голчтой үзэл бодолтой байх орчин, боломжийг бүрдүүлж, эрүүл саруул, өөрийнхөөрөө сэтгэл, үнэлэмж, эрх ашгаа хамгаалах үзэл бодолтой болох үйл зорилгод үйлчлэх учиртай. Тиймээс “танд өөрийн үзэл бодолтой байх эрх заяасан ч баримт үнэнийг өмчлөх мэдэл үгүй” хэмээх мөрдлөг гарсан хэрэг. Баримт үнэний дэргэд бурхад ч чимээгүй болдог гэсэн цэцэн үг ч өрнөдөд түгсэн нь үзэл бодлын дэнс, шалгуурт чухал. Үнэхээр ч бүгд эрх чөлөөтэй гэдэг үзэл бодлын ертөнцөд маргаантай бөгөөд эргэлзээтэй. Тиймээс ч өрнө дахинд бүр Платоны үеэс бодит (сонгодог) болон бүх нийтийн (сэтгэгдлийн) үзэл бодлын тухай ангилал гарчээ.

**И**йнхүү тодорхойлохдоо а) хувь сонирхлын оролцоо, б) оюун дүгнэлттэй эсэх, в) шинжлэх ухаанч эсэх гэсэн шалгуураар үнэлсэн хэрэг. Ингээд үзэл бодлыг (мэдлэг) “шалгагдсан” эсэхээр нь сэтгэгдлийн (марган мэтгэлцэх боломжгүй хэт хувийн үзэл давамгайлсан), адил, эн тэнцүү байр суурийн (хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх боломжтой, мэргэжлийн шалгагдсан байдал сул), мэдлэг, мэргэжлийн (шалгагдсан байдал, хөдлөшгүй баримтад тулгуурласан) гэж ангилжээ. Ийнхүү томьёолбол сэтгэгдлийн түвшинд хөл бөмбөгийн баг, хоол, хувцас загварын, байр суурийн солилцоо, илэрхийллийн хүрээнд улс төр, ёс суртахууны харин онцгой мэдлэгийхэнд физик, хими, математикийн тухай мэдлэгийг жагсаав.

Энэхүү үзэл бодлын үнэ цэнийн жагсаалтаас хэт хувь хүний сонирхол сэтгэгдлийн хандлагаас ангид, эн

тэнцүү мэтгэлцээн байр суурийн түвшний асуудал, агуулгыг онцлох нь сэтгүүл зүйн гол зорилго болох нь ойлгомжтой. Тэгээд ч асуудлыг олон нийтэд хүргэх, нээн тодотгох нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн мөн чанар гэдэг. Үүгээрээ асуудлыг шийддэг, нийгмийг уриалан дууддаг гэдэг үүрэг зорилго сэтгүүл зүйд үгүй бүр цаашилбал “хор уршигтай” үйл хандлага хэмээн тодорхойлж байгаа юм. Үнэхээр ч дарангуйлагч, хүний төрөлх эрхийг үгүйсгэсэн тогтолцоонд л нийгмийн мэдээлэл, харилцааны тогтолцоог үзэл суртлын хэрэгсэл болгож, түүгээрээ эрх баригч хүчний ашиг сонирхол, ноёрхлыг хамгаалдаг.

Харин манай судалгаанд оролцогсдын 55.6 хувь (2011 хүн) нь үзэл бодлын эрх чөлөөний үнэ цэнийг хүний төрөлх эрхийн баталгаа хэмээн үзсэн нь нийгмийн үнэлэмжийн түвшинд хүртэл батжин төлөвшсөний нотолгоо мөн. Түүнчлэн нийгмийн эрх ашгаа хамгаалах, хүний эрхийг хангах тэмцлийн үр ашигтай хэлбэрийг үзэл бодлоо илэрхийлэх гэсэн нь ч иргэний, ардчилсан улс төрийн тогтолцооны тулгуур, суурь зарчим биеллээ олж, төлөвшин буйн баталгаа болно. Ийнхүү санал асуулгад хариулагсдын тоо 83.3 хувь (3007 хүн) байгаа нь маш өндөр үзүүлэлт юм. Гэтэл өлсгөлөн зарлах 2.8 хувь (106 хүн), жагсаал цуглаан хийх 5.6 хувь (214 хүн), тэмцэл хэрэггүй гэж 8.3 хувь (317 хүн) хариулжээ. Өөрөөр хэлбэл үзэл бодлын эрх чөлөөг нийгмийн үнэлэмж болгон нутагшуулах таатай нөхцөл, олон нийтийн хандлага хангалттай байна гэсэн үг. Тэр дундаа улс төрийн парламентийн тогтолцоог үндсэн хуулийнхаа хүрээнд хүлээн зөвшөөрч баталгаажуулсан өнөөгийн нийгмийн хөгжил, дэвшилд үзэл бодлын ургальч байдлын үр нөлөө

онцгой чухал болой. Үүнд ч мэдээллийн хэрэгслийн үүрэг хариуцлага оршин буй нь тодорхой бөгөөд олон нийтийн санал бодлыг илүү бодит, зөв хандлагад чиглүүлэхийн үнэ цэн оршино. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ойлголт нь ч нэгдүгээрт улс төрийн соёл, үнэлэмжийнх, хоёрдугаарт мэдээлэл хайх, олж авах, түгээх үйл явцын тухайд илүү холбогддог. Үүнийг ч “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаг”-ийн 19-р зүйлд “хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” хэмээн баталгаажуулсан нь бий. Гэхдээ энэхүү эрх нь хувь хүний нэр хүнд, төрөлх эрхийг хүндэтгэх, улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах зорилго шалтгаанаар зөвхөн хуулиар хязгаарлагдах ёстойг Тунхагт заасан нь учиртай. Нэн ялангуяа мэдээллийн хэрэгслээр олон нийтэд үзэл бодлоо илэрхийлэх эрх нь нийгмийн болоод хүний эрх ашиг, үнэлэмжинд хамаарах тул үүрэг, хариуцлагын хэм хэмжээгээр зохицуулагдах зайлшгүй үр дагаврын хүрээнд үнэлж дүгнэх ёстой харилцааны мөрдлөг юм. Ер нь үзэл бодол гэдэг хүний оюун ухаант, нийгмийн “амьтан” хэмээх төрөлх мөн чанартай холбоотой. Хүн сэтгэж буй учир үзэл бодолтой болдог, үзэл бодолтойн учир нийгэм-

шин амьдардаг, нийгэмшинэ гэдэг зөвшилцөл, зөрчлийн дунд хүлцэн тэвчиж, үгүйсгэн өрсөлдөх зайлшгүйд эрхшээгддэг ба энэ бүхний дунд өөрийн үнэлэмж, байр суурь, итгэл үнэмшлээ олж авдаг. Тиймээс ч үзэл бодол гэдэг нэг талаас дотоод ертөнцийн “газрын зураг”, нөгөө талаас нийгэм бодит ахуйн нөлөө, дэмжлэг эсхүл дарангуйлал, шахалтаар бий болдог. Үүний нэгэн жишээ нь ч хүн, нийгмийн харилцааны түүх бөгөөд хэл яриа бий болсон цагаас үзэл бодлын эрин үе эхэлсэн гэдэг. Судлаачдын тодорхойлсноор үг хэлний үүсэл 100000-аас 1 сая жилийн өмнөөс тоологддог ба бичиг үсгийнх 5-6 мянган жилээр хэмжигддэг. Тэгээд ч бичиг үсэг нь үзэл бодлоо

«  
*Үзэл бодлыг (мэдлэг) “шалгагдсан” эсэхээр нь сэтгэгдлийн (марган мэтгэлцэх боломжгүй хэт хувийн үзэл давамгайлсан), адил, эн тэнцүү байр суурийн (хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх боломжтой, мэргэжлийн шалгагдсан байдал сул), мэдлэг, мэргэжлийн (шалгагдсан байдал, хөдлөшгүй баримтад тулгуурласан) гэж ангилжээ*

»

илэрхийлэх болоод түүнийг хянах түүгээр дамжуулан эрх мэдэл, нөлөөгөө тогтоох улс гүрний түүхийг хөдөлгөсөн гэдэг. Мэдээллийг хадгалах, түгээх боломж болоод цаг хугацаа, орон зайн хязгаарлалт дарангуйгаас үл хамаарах эрх чөлөөг бичиг үсэг хүн төрөлхтөнд өгсөн. Соёл иргэншлийн хувьд байгалийн бус тэргүүлэх хүчин зүйл нь ч бичиг үсэг, ном зохиол билээ. Ийнхүү бүр эртний Грекийн яруу найрагч Омир (МЭӨ 9-8 зуун) үг хэлэх эрх чөлөөг тунхаглаж, Афины ардчиллын лидер Перикл Афин болоод Спарта хот улсын ялгааг үзэл бодлын нээлттэй, ургальч байдалд тулгуурлан тодорхойлж байжээ. Үзэл бодлын эрх чөлөөний анхны агуу золиос нь ч

эртний Грек болоод бүх цаг үеийн суут сэтгэгч, гүн ухаантан Сократ байсан нь санаандгүй хэрэг биш бөгөөд түүнд залуу үеийг үл ойлгогдох бурхны сургаалаар “буртагласан” гэх ял оноон хор уулгасан түүхтэй.

**Ө**рнөдийн түүхийн гэгээрлийн эрин хүртэл (XVII-XVIII зуун) үзэл бодлын цагдан хяналт нь төр барихуйн гол арга хэлбэр болж, эрх мэдэл, нөлөөллийнхөө эсрэг аливаа эргэлзээтэй, өөр санаа бодол, эш үзлийг хамгийн хатуу хэрцгийгээр хориглон шийтгэж ирсэн. Хүн төрөлхтний технологийн агуу нээлт болсон Гутенбергийн хэвлэх төхөөрөмж нь нэг талаас ном хэвлэлийг бүх нийтийн хүртээл болгох хувьсгал, нөгөө талаас хяналт, хязгаарлалтын хүч нөлөөний хүчирхэгжлийг дагуулсан. Үзэл бодлын цагдан хяналтын цөм нь католик шашны дарангуйллын төв Ватикан байж 1559 онд хориотой номын жагсаалтыг гаргасны дотор Н. Коперникийн “Тэнгэр огторгуйн эргэлтийн тухай” хэмээх шинжлэх ухааны эринийг эхлүүлсэн бүтээл багтсан нь санамсаргүй хэрэг бус аа.

Дахин сэргэлтийн үе нь ч үзэл бодлын эрх чөлөөний төлөөх хатуу ширүүн тэмцлийн жишээ болж “Оддын танхим” хэмээх цагдан хяналтын анхны байгууллагыг Английн хаант төр байгуулсан түүхтэй. Улс төр, шашны аливаа үзэл санааг нухчин дарахад “Оддын танхим” тэргүүлэн, онцгой үүрэг гүйцэтгэж байсан ч зөвшөөрөлгүй сонин хэвлэл, шог найрууллын эрч далайцыг хумиж чадаагүй. Ийнхүү үзэл бодлын эрх чөлөөний анхны улс төр, гүн ухааны үндэслэлийг 1644 онд Жон Мильтон “Ареопагитика” хэмээх алдарт бүтээлдээ тодорхойлон “үнэнийг олох хамгийн найдвартай зам нь үзэл бодлын чөлөөтэй, нээлттэй солилцоо,

илэрхийлэл” хэмээн тунхаглажээ. Энэхүү хүний төрөлх эрхийг анх хүлээн зөвшөөрсөн улсаар 1766 онд Швед түүчээлж, үзэл бодлын цагдан хяналтыг устгасан ба 1770 онд Дани, Норвеги удаалан баталжээ. Харин дэлхийн түүхэнд онцгойлон үздэг үйл явдал 1789 онд Францын үндэсний хурлаар баталсан “Хүний эрхийн тунхаглал” бөгөөд түүнээ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэвлэн нийтлэхтэй хамтатган баталгаажуулсан нь юм. Ийнхүү 1791 оны АНУ-ын үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлтээр “Конгресс шашин шүтэх, үзэл бодлоо илэрхийлэх болон хэвлэн нийтлэх эрхийг хязгаарлах ... ямарваа нэгэн хууль батлахгүй” гэсэн заалтыг баталсан нь хүн төрөлхтний оюун санааны томоохон ололт болсон билээ. АНУ болон өрнөдийн орнуудад XX зуун хүртэл хүний эрхийг өргөжүүлэн тэлэх хийгээд хэвлэл мэдээллийн хэрэгслийн хяналтыг хязгаарлах зарчмаар үзэл бодлын эрх чөлөөний хөгжил өөрчлөлт өөрийн жам ёсны замаар өрнөн дэвшиж байв. Гэвч дэлхийн нэгдүгээр дайны дараа тоталитар дэглэм дахин сэргэж хүний эрх чөлөө бүхий л талаар үгүй болж эрх баригч хүчин, төрийн үзэл суртал дарангуйллын гол эрх хүч, мэдээлэл үзэл бодлыг хяхан хавчих үндэслэл зарим тохиолдолд хуульчлагдсан нь бүхнийг эргүүлсэн хэрэг мөн. Мэдээж хамгийн хатуу эл шийтгэл, мөрдөлт, цагдан хяналт үзэл бодлын ертөнцөд үйлчилж, өөр, ургальч үг санааг хүчирхийлэн дарж байв.

Коммунизм, фашизм, Хятадын соёлын хувьсгал гээд хяналт, цагдалтын арга хэлбэр төрийн үндсэн, гол үйл хэрэг бодлого, хууль эрх зүйн суурь зарчим болсон үзэл суртлын дарангуйлал, “Нийгмийн инженерчлэл”-ийн эрин үе нь XX зуун байсан. Хүйтэн

дайны төгсгөл, ЗХУ-ын задрал, социалист орнуудын нийгэмлэг үгүй болсон 1990 оноос л хүн төрөлхтөн дахин үзэл бодлын эрх чөлөөт бүх нийтийн үнэт зүйл, эрхэм, зайлшгүй зорилго болгосон билээ.

Дээрх түүхийн товчоог нэгтгэн үзвээс үзэл бодлын эрх чөлөөний гол аюул нь төр болоод шашны эрх ашиг сонирхол, үзэл суртал гэдэг нь тодорхой юм. Нийгэм, эдийн засаг, улс төр тэр бүү хэл соёл, боловсролын харилцаа, дэг журам, ертөнцөд төр хүчтэй байх, бүхнийг эрхшээхийн суурь хүчин зүйл нь үзэл бодлын эрх чөлөөг хязгаарлах юм. Ерөөс үзэл бодлын эрх чөлөөний түүх ч төр болоод шашны үзэл суртлын дарангуйлал, хаалт хязгаарлалт болоод хүний оюун санаа, итгэл үнэмшил, үнэт зүйлийн хөгжил дэвшил хоорондын зөрчил, ялалт ялагдлын он жилүүд байжээ. Өнөөдөр ч Жулиан Асанж, Сноуден гээд үзэл бодол, мэдээллийн эрх чөлөөний төрийн (АНУ) мөрдөн мөшгилт хэвээр үргэлжилсээр л байна. Гэтэл нийгэм, хүний эрх чөлөөг эрхэмлэгч АНУ-ын Үндсэн хууль, төрийг үндэслэгч Ж. Вашингтон “Хэрвээ үг хэлэх эрх чөлөөг үгүй хийх аваас биднийг хонь адил дүлий мунхаг болгон дарангуйллын хашаанд туусантай адил болно” гэж хэлснийг дэлхий дахин мэднэ.

**Э**ндээс үзэл бодлын эрх чөлөөний хяналт үгүйсгэлийн түүхийн бүх цаг үед байсан гол үндэслэл нь “илүү сайн сайхан, үнэн”-ий төлөө төр эсхүл шашин хэний ч үзэл бодлыг хориглох эрхтэй хэмээх томъёолол юм. Гэхдээ эргээд ямар үндэслэл, шалгуураар “илүү сайн, үнэн”-ийг тогтоож буй эсэх, хэн шүүн дүгнэж байгаа, хэнд тийм эрхийг яагаад, хэн өгсөн гээд асуулт гарна. Тиймээс асуудлын уг чанар, эцсийн

“шүүлтүүр” нь хүн бүрт өөрт нь “юу сайн, зөв гэх эрх, яагаад тийнхүү үнэлж дүгнэж буй”-н шалгуур, шаардлага байгаа гэсэн хариултад хүрнэ. Үүнд ч Волтер маягаар өгүүлсэн “чиний хэлсэнтэй санал нэгдэхгүй байгаа ч амьд байгаа цагтаа энэ ертөнцийг л үгүй хийчихгүй бол хэлж ярих эрхийг чинь хамгаалах болно” гэсэн үгсийн утга чанар оршино. Өөрөөр хэлбэл үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үнэ цэн өөрийн бус харин бусдын үг хэлэх, итгэл үнэмшилтэй байх эрхийг хүлээн зөвшөөрөх дээдлэхэд оршино гэсэн үг. Тиймээс ч эрх мэдэл, засаглал эсхүл өөрийн үнэн зөвийг дээдлэгч хэн нэгэн үзэл бодлын эрх чөлөөнд дайсагнаж байгаа нь хүлцэн тэвчих, бусдынхыг илүүд үзэх эрхэмлэл, зарчмыг үгүйсгэж буйд оршино. Мэдээж энэ нь хэцүү түвэгтэй ч үүнээс өөрөөр оюун санааны эрхийг бодит зүйл болгож чадахгүй. Оюун ухаан, итгэл үнэмшил, үнэлэмж, хүлцэн тэвчихүйн соёл гээд энэ бүхэн нь үзэл бодлын эрх чөлөөний үнэ цэн, зорилго, мөн чанар болно. Шинжлэх ухааны ч хөгжил дэвшил өмнөх үеийнхээ мэдлэгийг няцаахад оршиж, эргэлзээ үгүйсгэлийн шалгуураар урагшилж ирсний шалтгаан нь ч хүний сэтгэлгээний чөлөөт, өөрийнхөөрөө байх эрхийг дээдэлсэнд байгаа юм. Тэгэхлээр үзэл бодлын эрх чөлөө нь нэгдүгээрт миний биш бусдын эрх гэдгийг ухаарах, хоёрдугаарт хүлээн зөвшөөрүүлэх, нотлоход бус, харин хүлцэн тэвчих, хүлээн зөвшөөрөхөд зорилго нь оршдог, гуравдугаарт эрх, шалгуур нь төр эсхүл шашинд биш харин хувь хүнд байдаг үнэт зүйл хэмээх томъёололд нэгтгэгдэх болно.

Бидний хийсэн судалгаагаар ч оролцогсдын 80.6 хувь (2913 хүн) өөрийн үзэж өнгөрүүлсэн амьдрал

итгэл үнэмшлээр үзэл бодлоо төлөвшүүлдэг, нийгмийн сүлжээг хамгийн нөлөө бүхий хэрэгсэл (91 хувь буюу 3120 хүн) хэмээн үзсэн нь учиртай. Интернет сэтгүүл зүйн хэрэглэгч хоорондын эргэх холбоогоор харилцаа, сүлжээний орчноо бүрдүүлдэг “чанар” нь хувь хүний оролцоо, хайлт, дахин дамжуулал, хадгалах үйл явц, боломжийг нээлттэй болгосон нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний мөн чанарт хамгийн эерэгээр нийцэж буй хэрэг юм. Нөгөө талаар үзэл бодлын ба хэвлэлийн эрх чөлөө нь өөр хоорондоо уялдаа холбоотой тэр дундаа мэдээллийн хэрэгслийн нээлттэй байдал нь (57,1 хувь буюу 2011 хүн) бүхний үндэс болохыг судалгаанд оролцогсод онцолжээ. Тиймээс ч сэтгүүл зүйн нийгмийн өмнө хүлээх тэргүүн зэргийн үүрэг хариуцлагыг хүний “мэдэх эрх”-ийг хангах хэмээн үздэг. Энэ нь нийгмийн янз бүрийн бүлэг хүрээний эрх ашиг, байр суурийн илэрхийлэл болсон ургальч үзэл, бодлын “гүүр”, “индэр” байхыг тодотгож байгаа юм. Тиймээс ч хэдийгээр маргаантай, нэлээд эргэлзээтэй ч зөв, голчтой үзэл бодлыг илэрхийлэгч нь ард түмэн хэмээн судалгаанд оролцогсдын 42.9 хувь (1497 хүн) нь үзсэн бол улс төрчид гэсэн хариултыг хэн ч өгсөнгүй. Гэхдээ энэхүү асуултад нийгмийн зүтгэлтнүүд гэж 37.1 хувь, бизнес эрхлэгчид хэмээн 14.3 хувь тус тус хариулсан нь ардчилсан, иргэний нийгмийн хөгжлийн эхэнд яваа манай орны хувьд чамлахаар үзүүлэлт биш юм. Үнэхээр ч Монголын нийгэм, эдийн засгийн тогтолцоо хэдийгээр зөрчил, хямрал, саад бэрхшээл дүүрэн ч харьцангуй зөв голчтой элдэв хүчирхийлэл, мугуйд үзэл бодлоос ангид ардчилал, зах зээлийн жам ёсны орчин уруу аажим боловч шилжиж буй нь бидний энэ

цагийн түүх юм. Тийнхүү хувь хүний ухамсар, амьдралын туршлага шинэ цагийн үнэнийг өөрөө нээн таньж илүүдэг журмыг эрхэмлэгч, эргэцүүлэн тунгаах чадвартай нийгмийн “эд эс” болж байгаад эргэлзэх зүйлгүй.

Сэтгүүл зүй ч бурангуй үзэл, худал амлалт, хийрхэл туйлшралыг бага багаар боловч үгүйсгэж нийгэм хүний “өөрөө өөрийнхөө төлөө амьдрах” сэтгэлийн тэнхээ, итгэл үнэмшлийг төлөвшүүлж байгаа билээ. Манай судалгаанд оролцогсдын 32.3 хувь нь “үзэл бодол”-ын сайн нэвтрүүлгээр “Монгол тулгатны зуун эрхэм”, 21.1 хувь нь эдийн засагч Д. Жаргалсайханы “Де факто”, 9.6 хувь нь “Цензургүй яриа” зэргийг онцолсон нь өнөөгийн мэдээллийн эрэлт хэрэгцээ үзэгчдийн сонирхол илүү буурь суурьтай, тэнцвэртэй, эрүүл үзэл бодлыг эрэлхийлж буйн бодит нотолгоо мөн.

**Ө**өр нэгэн сонирхол татаж буй асуудал бол өнөөгийн нийгэмд ямар үзэл санааг түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй гэж олон нийт үзэж буй тухайд оршино. Хариултын 37.1 хувь нь “ухаалаг, хүчтэй, хариуцлагатай төрийн манлайлал”, 20.1 хувь нь “үндэсний соёл сэтгэлгээг дээдлэх” гэсэн улс орны тусгаар тогтнол, бие даасан байдлын үнэлэмжид нэгтгэгдэж байна.

Өөрөөр хэлбэл манай олон нийт төрийг дээдлэх, үндэсний бахархлыг эрхэмлэх үзэл санааг бүхнээс тэргүүнд тавьж, “өмчлөх эрх”, “нийгмийн бие даасан байдал”, “технологи, үйлдвэрлэл, эдийн засгийн бодит нөлөө, эрх мэдэл” зэрэг өрнөдийн соёл иргэншлийн үнэлэмжийг төдий л онцлохгүй байна гэсэн үг. Энэ нь ч нийгмийн үзэл бодлын зөрчил ээдрээт дүр байдлын бодит шалтгаан мөн. Нэг талаас хувь хүний бие даасан байдал, өөрийн-

хөөрөө байх эрх, өмч, нийгмийн эрх ашгийг үнэлэмжээ болгодог үзэл санааны иргэншил болох ардчилал, зах зээлийн тогтолцоо, нөгөө талаас төрийг дээдэлдэг уламжлалт зан сэтгэхүй, хөрөнгөжсөн хэсгийг үл ойшоодог “коммунист дэглэм”-ийн санагалзал, өрнөдийн соёл, хэрэглээнд хэт шүтсэн эрмэлзэл зэрэг өнөөгийн олон нийтийн санаа бодлын хооронд үзэл бодлын хямрал, үл ойлголцол оршин байна.

Гэхдээ өмнө тэмдэглэснээр үйл явц эерэг нааштай байгаа ч хүн төрөлхтний сайн сайхан, үлгэр жишээ боох эрүүл оюун ухааны үзэл санаа нийгмийн харилцаа амьдралын “суурь, хөрс” болтлоо бас хол, олон бэрхшээл саадыг туулах болно. Мухар сүсэг, бүхнээ тэтгүүлэх далдын хүсэл, эдийн засаг нийгмийн хөгжлийн талаарх өнгөц хуурмаг ойлголт, төсөөлөл, ард түмэнч, өнгөрсөн үеэ санагалзах тоталитар үзэл суртлын улбаа болон хүчтэй ухаантай удирдагчийг дээдлэх хандлага гээд олон зөрчилт сөрөг “агуулга” манай олон нийтийн санаа бодолд амь бэхтэй хэвээр байна.

Үүнд ч популист улс төр, гадаадын хөрөнгө оруулалтын эсрэг “хөдөлгөөн”, эдийн засаг, амьжиргааны уналт, хямрал, технологийн хоцрогдол, үйлдвэрлэл санхүүгийн дорой байдал, хомсдол нөлөөлж байгаа. Ийнхүү нэгтгэн дүгнэвэл үзэл бодлын эрх чөлөөний эерэг таатай орчин, бодит нөлөөний хөгжил, төлөвшилд олон нийтийн санаа бодлын хэт дарангуйлал гол саад, хориг хязгаарлалт болж байна гэсэн үг.

Үзэл бодлын эрх чөлөөний өөр нэгэн зайлшгүй хүчин зүйл, чанар нь идэвхтэй оролцоо, нээлттэй орчин, бодит үр дүн болой. Мэдээж үзэл

бодлоо илэрхийлж, тэр нь ямар нэг нөлөө, үр дүнд хүрч байж эрх чөлөө бүрэн утгаараа үнэ цэнтэй болно. Манай судалгаанд оролцогсдын дийлэнх буюу 51.1 хувь нь (1803 хүн) үзэл бодлоо мэдээллийн хэрэгслээр илэрхийлж байсан гэсэн нь нэлээд өндөр үзүүлэлт юм. Гэвч үр дүнд хүрээгүй гэж 58.3 хувь (2097 хүн) мэдэхгүй хэмээн 16.7 хувь (597 хүн) хариулсан нь үзэл бодлын эрх чөлөөний өнөөгийн гол тулгамдсан асуудал, зөрчил болоод байна. Энэ нь ч өгүүллийн эхэнд онцолсон эрх чөлөөний үнэ цэн, үнэлэмж буурч буйн нотолгоо, нэгэн шалтгаан билээ. Үүнийг ч манай хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгэмд хэрэгтэй, үр дүнтэй үзэл бодлыг түгээж чадахгүй байна гэж судалгаанд оролцогсдын 65.7 хувь үзсэн тоо баримт тодотгов. Бас хариулж мэдэхгүй 1087 хүнийг (31.4 хувь) нэмбэл үр дүн, нөлөөний талд дөнгөж 2.9 хувь л үлдэв.

Энэ бүхэн нь үзэл бодлын эрх чөлөөний үндсэн мөн чанар болох бусдын санаа бодол, байр суурийг хүлээн зөвшөөрөх, хүлцэн тэвчих соёл нутагшаагүй, зөвхөн өөрийн эрх ашгийн хүрээнд үнэлж ойлгодог олон нийтэшсэн дүр сэтгэхүүд автсан бидний нийгмийн үр дагавар юм. Үнэхээр ч үзэл бодлын эрх чөлөөний төвд оршдог “Би”-гийн дээдлэл нь “өөрийгөө шүтүүлэх, дур зоргоор байх”-аар хэтийдэн мөн чанараа гээсэн нь зөрчил хямралыг дагуулж байна. Тэр бүү хэл энгийн олон нийтийн дундаас бүр төрийн бодлого, эдийн засгийн амьдралын дэг, хэм хэмжээнд хүртэл нөлөө, ноёрхлоо тогтоож байгаа нь бидний эмгэнэл юм. Энэхүү бэрхшээл саадыг даван туулах гол зам “жор” нь эцсийн дүнд монгол хүн, Монголын нийгмийн ухаарал, соёл, хөгжилд оршино. Үүнийг төлөвлөгөөт, бүх



нийтийг хамарсан зохион байгуултат мэдээллийн довтолгоо тэр дундаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр шийдэж сайн сайхан, зөв гольдролд оруулж чадахгүй. Сэтгүүл зүй нь нийгмийн харилцааг нээлттэй болгох, ургальч үзэл бодлыг дэмжих, бодит асуудал, үнэнийг дэлгэн хүргэхэд үүрэг зорилгоо нэгтгэх ёстой. Гэхдээ энэ бол үзэл бодлын эрх чөлөөний үнэ цэнийг өргөх, үр дүн нөлөөг тэтгэх хамгийн гол нөхцөл, шийдэл мөн. Үзэл бодол ч хэзээд төгс байдаггүй, байх ч боломжгүй агаад тухайн цаг үе, ахуй байдал, тулгамдсан бүхнээс шалтгаалдаг, үргэлж өөрчлөгдөн хувьсч байдаг “амьд” ертөнц. Үүнд ч эрх чөлөөний учир шалтгаан, зайлшгүй чанар оршдог.

**Э**цэст тэмдэглэхэд “үзэл бодол сайхан ч амьдралд өөр” гэдэг үгийн мөн чанар эрх чөлөөнийх нь уг сурвалж, мөрдлөг болохыг гүнээ ухаарч, үнэлж цэгнэж байх учиртайг онцлов.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Blumer H.* 1953. The Mass, the Public, and Public Opinion // Reader in Public Opinion and Communication / Ed. by Berelson B., Janowitz M. New York.
2. *Lasswell H. D.* 1960. The Structure and Function of Communication in Society // Mass

Communications / Ed. by Schramm W. Urbana.

3. *Алфандари, Елиезер.* 2000. Медиите и властта. София.

4. *Липман, Уолтър.* 2001. Обществено мнение. София.

5. *Ноел-Нойман, Елизабет.* 1992. Въздействието на масмедиите // Психотехника на убеждаващото въздействие. София.

6. *Березин В. М.* 2002. Сущность и реальность массовой коммуникации. М.

7. *Кастельс М.* 2000. Информационная эпоха. Экономика, общество и культура. М.

8. *Маклюэн М.* 2003. Галактика Гутенберга. Киев.

9. *Маклюэн М.* 2003. Понимание медиа: Внешние расширения человека. М.

10. *Мелюхин И. С.* 1999. Информационное общество: истоки, проблемы, тенденции развития. М.

11. *Прохоров Е. П.* 2003. Введение в теорию журналистики. М.

#### Резюме

В настоящей статье автор подверг исследованию одно из ключевых понятий журналистики и демократии – свободу выражения мнений на практике. Опрос, проведённый в мае 2015 года и охвативший 3700 респондентов, показал, что подавляющее большинство из них (75% или 2709 респондентов) считает, что хотя и существует свобода выражения мнений, реальной пользы и конкретного результата от этого нет, что свобода выражения мнений в конечном итоге превращается в пустую полемику. Кроме того, 19,3% респондентов подчеркнули, что в действительности свобода выражения мнений ограничена.